



**“МАНДАЛ ДААТГАЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 03 сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

“Мандал Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 03 сарын 28-ны өдөр 12:00 цагаас 13:33 цагийн хооронд компанийн албан ёсны фэйсбүүк <https://www.facebook.com/mandaldaatgal> хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр хуралдав. Санал хураалт болон асуултыг www.investmentexpo.mn цахим системээр хураав.

Хурлын дарга:	Өлзийбаярын Ганзориг
Хурлын нарийн бичгийн дарга:	Даваадоржийн Дөлгөөн
Тооллогын комисс:	М.Сэнгэдорж (Комиссын дарга) Б.Оюунчимэг (Комиссын гишүүн)

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн тоо: 28

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо:
485,184,571 ширхэг

Хурлын ирц: 81.81% буюу дийлэнх олонх.

НЭГ. МЭДЭЭЛЭЛ

Тооллогын комиссын дарга М.Сэнгэдорж: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц хураалтын аргачлал болон “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн хурлыг шийдвэрээр томилогдсон Тооллогын комиссоос ирүүлсэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн Хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Дөлгөөн: “Мандал Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах шийдвэрийг 2026 оны 02 сарын 10-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн ээлжит хурлаас шийдвэрлэсэн тухай мөн уг шийдвэрийн дагуу 2026 оны 02 сарын 14-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг хүргүүлсэн тухай танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 2026 оны 02 сарын 16-ний өдөр болон 2026 оны 02 сарын 27-ны өдрүүдэд тус тус мэдээлснийг танилцуулав.

Хурлын зар болон хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2026 оны 02 сарын 13-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан болохыг мэдэгдэв. Мөн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрийг 2026 оны 03 сарын 02-ний өдрөөр тогтоосныг танилцуулав.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэгийг танилцуулав.



ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

- 1 дүгээр асуудал: Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
- 2 дугаар асуудал: Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
- 3 дугаар асуудал: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- 4 дүгээр асуудал: Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
- 5 дугаар асуудал: ТУЗ-ийн ердийн гишүүд сонгон шалгаруулж батлах;
- 6 дугаар асуудал: ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

1 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга: “Мандал Даатгал” ХК-ийн 2025 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг товч танилцуулав.

2025 оны санхүүгийн тайлан: Мөнгөн хөрөнгө 79.6 тэрбум төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс 10.5 тэрбум төгрөгөөс өссөн байна. Эздийн өмч 49.6 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт хөрөнгө 137.8 тэрбум төгрөгт хүрсэн.

2025 оны орлого үр дүнгийн тайлан: Нийт хураамжийн орлогыг 155.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх жилээс 10.4 тэрбум төгрөгөөс өссөн. Хөрөнгө оруулалтын орлого 9.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх жилээс 0.6 тэрбум төгрөгөөр өссөн. Нөхөн төлбөрийн зардал 27.4 тэрбум төгрөг хүрч өмнөх жилээс 10 тэрбум төгрөгөөр өссөн. Үйл ажиллагааны зардал 13.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх жилээс 0.7 тэрбум төгрөгөөс өссөн байна. Цэвэр ашиг 13.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх жилээс 4.8 тэрбум төгрөгөөс өссөн байна.

2025 оны ашигт ажиллагааны үзүүлэлт: Эздийн өмчийн өгөөж (ROE) 28% , Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 10% байсан.

Даатгалын салбарын 2025 оны тойм: Санхүүгийн үр дүнгээр салбарт эзлэх байр суурийн хувьд Мандал Даатгал нь нийт Хөрөнгийн хэмжээгээр 1-т, нийт Нийт мөнгөн дүнгээр 1-т, нийт Хураамжийн орлогоор 1-т, Хөрөнгө оруулалтын орлогоор 1-т, Цэвэр ашгийн хэмжээгээр 1-т тус тус жагсаж байгааг танилцуулав.

“Мандал Даатгал” ХК-ийн хувьцааны үзүүлэлт: “Мандал Даатгал” ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 624,301,600 ширхэг, 2025 оны хаалтын ханш 69.25 төгрөг, Зах зээлийн үнэлгээ 43.2 тэрбум төгрөг, 2025 онд нийт 1.7 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн, 2024 оны өдрийн дундаж арилжаа 87.3 сая төгрөг байсныг танилцуулав.

“Мандал Даатгал” ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Эрсдэлийн Форумыг 14 жил тасралтгүй явуулсан бөгөөд тус форумгаар нийгэмд тулгараад байгаа эрсдэлүүдийг ойлгуулж, түүнээс сэргийлэх зорилготой бөгөөд энэ жил 15-дах удаа зохион байгуулна гэдгийг дурдав. Мөн, Мандал Эрсдэлийн Сургууль, Эрүүл Мэндийн нэгдсэн сан болох



EDOCTOR вебсайт, Ажлын байрны тэтгэлэгт оюутан хөтөлбөр, “Алтеплаза” 50 хүний амь нас аврах төсөл, “Голын Эргийн Камер” төсөл зэргийг танилцуулав.

2 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн хорооны дарга Г.Гантулга

Танилцуулгын гол агуулга:

“Мандал Даатгал” ХК-ийн 2025 оны 10 сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлын 25/011 тоот тогтоолоор “Мандал Даатгал” ХК-ийн 2025 оны Санхүүгийн тайланг батлах хөндлөнгийн аудитын компаниар “Нексия Глобал Монголиа Аудит” компанийг сонгосон. “Нексия Глобал Монголиа Аудит”-ын фирм нь Олон улсын аудитын франчайз бөгөөд “Мандал Даатгал” ХК-ийн санхүүгийн тайланг сүүлийн 3 жил хийсэн.

Дүгнэлтийн товч агуулга: Бид “Мандал Даатгал” ХК-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын зөвлөлөөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

3 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

Танилцуулсан: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Дөлгөөн

Танилцуулгын гол агуулга:

“Мандал Даатгал” ХК-ийн эрхэм харилцагч, хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч та бүхэнд 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, 2025 оны зорилго зорилтуудын гүйцэтгэлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Санхүүгийн үйл ажиллагаа:

“Мандал Даатгал” ХК-ийн 2024 оны 12 сарын 05-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын №24/020 тоот тогтоолоор “Мандал Даатгал” ХК-ийн 2025 оны Бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны стратегийг баталсан.

“Мандал Даатгал” ХК нь 2025 оны Нийт хураамжийн орлого 155,6 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 7,2%-иар өсөж, нийт даатгалын зах зээлийн 29%-ийг эзэлж байна. 2025 онд 18,460



харилцагчдад 27.4 тэрбум₮-ийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оноос 58%-иар өссөн бөгөөд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт зах зээлийн 14%-ийг эзэлснээр салбартаа нөхөн төлбөр олголтоор 2 дугаар байрт жагсаж байна.

2025 онд хөрөнгө оруулалтын дүн 77.4 тэрбум төгрөгт хүрснээр хөрөнгө оруулалтын ашиг өмнөх оноос 0.8%-иар өсч салбартаа тэргүүлэгч нь байсаар байна. “Мандал Даатгал” ХК нь 2025 онд нийт 18,460 даатгуулагчид 27,4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгож, нийт нэхэмжилсэн нөхөн төлбөрийн 94.2%-ийг төлсөн байна.

“Мандал Даатгал” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитаар олон улсын “Нексия Глобал Монголиа Аудит” ХХК ажилсан бөгөөд “Мандал Даатгал” ХК-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт - 17 /СТОУС-17/-ын дагуу үнэн, зөв бодитойгоор илэрхийлсэн гэж дүгнэсэн байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажил:

“Мандал Даатгал” ХК нь 2025 онд “50 ХҮНИЙ АМЬ АВРАХ” төслөө үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажилласан.

Үүний нэг нь “**АЛТЕПЛАЗА**” төсөл

Алтеплаза нь хурц шигдээс, харвалтын үед анхны шинж тэмдэг илэрснээс хойш алтан цаг буюу 2-4 цагийн дотор хийгдэх өндөр түвшний эмчилгээ юм. Ингэснээр тухайн харвалтаас үүдэж бий болох хөдөлмөрийн чадвар алдалт, саажилт, амь насаа алдах эрсдэл багасна. Хэдий хүний амь насыг богино хугацаанд аврах шидтэй ч гэлээ, нэгж алтеплаза тунгийн үнэ өртөг нь өндөр учраас улсын хэмжээнд хүртээмж, нөөц хангалтгүй байдаг. Иймээс бид гурав дахь жилдээ Улсын Гуравдугаар Төв эмнэлэгтэй хамтран уг төслийг амжилттай хэрэгжүүлж, Монгол улсын нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болох хурц шигдээс, харвалтыг бууруулах Алтеплаза тарилгыг нийлүүлэн нийт 38 хүний алтан амийг авраад байна.

Дараагийн төсөл нь Үер, усны ослын эрсдэлийг бууруулах зорилго бүхий “**ГОЛЫН ЭРГИЙН КАМЕР**” төсөл

“Мандал Даатгал” ХК нь “Нийслэлийн Онцгой Байдлын Ерөнхий Газар”-тай хамтран үер, усны ослыг бууруулах зорилгоор Туул голыг дагасан үер, усны ослын хамгийн өндөр эрсдэлтэй цэгүүдэд аюулыг мэдээлэх 5 цамхгийг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг ханган ажилласаар байна. Уг цамхаг нь үер, усны ослын эрсдэлтэй тохиолдлыг 200 метрийн радиуст татаж харах чадалтай хяналтын камертай ба дуут дохио ашиглан иргэдэд сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэдэг. Уг камерыг байршуулснаар үер, усны ослын тохиолдол 3.5 дахин буурсан эерэг үр дүн гарсан байна.

Бага насны хүүхдүүдэд эрсдэлийн боловсрол олгох “**МАНДАЛ ЭРСДЭЛИЙН СУРГУУЛЬ**”

Бидний 4 дэх жилдээ хэрэгжүүлж буй бага насны хүүхдүүдэд эрсдэлийн боловсрол олгох зорилготой “Мандал Эрсдэлийн сургууль” нь 2-12 насны хүүхдүүдэд тэдний хөгжлийн онцлогт суурилан түгээмэл тохиолдох эрсдэлүүдийн талаарх 3 бүлэг 20 видео онлайн хичээлийг үнэ төлбөргүй бэлтгэн хүргэж, Нийслэлийн 400 гаруй цэцэрлэгийн сургагч багш нарт сургалтын мэдээллийг хүргэсэн байна.



Мөн бид иргэдийн эрүүл мэндийн суурь боловсролыг нэмэгдүүлэх, иргэдэд баталгаатай эх сурвалжаас мэдээлэл авах боломжийг бий болгох үүднээс Монголын хамгийн анхны эрүүл мэндийн цогц платформ болох **eDOCTOR** цахим хуудсыг хөгжүүлсэн. eDoctor платформ нь 1.5 сая гаруй тогтмол уншигчтай болсон бөгөөд мэргэжлийн эмч нарын бэлтгэсэн 250 гаруй өвчний дэлгэрэнгүй мэдээлэл, 100 гаруй зөвлөмж нийтлэл, шинж тэмдэг дээр суурилсан өвчний асуумж ба зөвлөмж, эрүүл мэндийн тооцоолуур, эмнэлэг хайх зэрэг олон зүйлийг нэг дор багтааснаар онцлогтой юм.

АЖЛЫН БАЙРТАЙ, ТЭТГЭЛЭГТЭЙ ЭЛСЭЛТ

“Мандал Санхүүгийн Нэгдэл”-ийн охин компаниуд нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуультай хамтран Санхүү&Банкны бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Уг хөтөлбөрийн хүрээнд нийт 28 оюутныг ажлын байраар хангахын зэрэгцээ, их сургуулийн сургалтын төлбөрийг шийдвэрлэсэн байна. Ингэснээр бид 3 жилийн хугацаанд бакалаврын зэрэг эзэмших бөгөөд онолын ба практик мэдлэгийг эзэмшиж, топ мэргэжилтэн болж төлөвших боломжийг бүрдүүлж байгаа юм.

БИЗНЕСИЙН ОРЧИН, МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

“Мандал Даатгал” ХК нь жил бүр нийгэм, эдийн засагт тулгарч буй эрсдэлүүдийг шийдэх арга замыг эрэлхийлж, менежментийн арга туршлагаа хуваалцах зорилгоор Монголын ТОП бизнес эрхлэгчдэд зориулан “Next Leaders”, “Management Forum”, “Эрсдэлийн форум” зэрэг арга хэмжээг зохион байгуулдаг. Тус арга хэмжээнүүд нь бизнес эрхлэгчдэд хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, бизнесийн хүрээлэл болон борлуулалтаа тэлэх боломжийг олгодгоороо онцлогтой.

2025 онд “Мандал Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг бизнес төлөвлөгөөний зорилт, стратегийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, бодитой үр дүн гаргаж ажилласан тул **Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.**

4 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

“Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 01 сарын 30-ны өдрийн ээлжит хурлын 26/005 тоот шийдвэрээр ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болохыг танилцуулав. Нэгж хувьцаанд 14.74 төгрөгийн ногдол ашиг олгох бөгөөд нийт 8,742,095,304.08 төгрөгийн ногдол ашгийг хуваарилна. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосон. Ногдол ашгийг 2026 оны 03 дугаар сарын 31-ний дотор “Үнэт цааны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах байдлаар хуваарилах болохыг мэдэгдэв.

5 ДУГААР АСУУДАЛ:

ТУЗ-ийн ердийн гишүүд сонгон шалгаруулж батлах;



Танилцуулсан: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Дөлгөөн

Танилцуулгын гол агуулга:

“Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд байсан О.Ганжолоо, Н.Мэндбаяр нар нь өөрсдийн хүсэлтээр гарсан бөгөөд, оронд нь хоёр ердийн ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлж танилцуулав. Томас Патрик Холланд болон Спенс Роберт Хектор Жон.

6 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

Компанийн ТУЗ-ийн дарга болон ердийн гишүүн, хараат бус гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын цалин урамшуулал 189.6 сая төгрөг, Бичиг хэргийн зардал 36.0 сая төгрөг, Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын зардал 20.0 сая төгрөг нийт 245.6 сая төгрөгийн төсвийг батлуулахаар танилцуулав.

АСУУЛТ, ХАРИУЛТ

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга асуулт хариулт эхэлснийг зарлаж тооллогын комиссын даргаас хувьцаа эзэмшигч нараас ирсэн асуултуудыг авав. Цахим хэлбэрээр хувьцаа эзэмшигчдийн хурал явагдаж байгаа тул бүх асуултад хариулах боломжгүй, асуултуудыг агуулгын хувь ижил болон олон давхацсан асуултуудад хариулахаар сонгосныг тайлбарлав.

Асуулт 1:

Мандал даатгал зах зээл дээр эзлэх хувиа тогтмол барих дээр ямар арга хэмжээ авч байгаа вэ?

Хариулт Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин:

“Мандал Даатгал” ХК нь 2026 онд зах зээлээ тэлэх, бүтээмжээ нэмэгдүүлэх, технологийн шийдэл гаргах, эрсдэлийн боловсрол олгох 8 төсөл хэрэгжүүлээд явж байна. Энэхүү төслүүдийг амжилттай хэрэгжүүлснээр салбарын тэргүүлэгч байр сууриа хадгалан зах зээлээ улам тэлэх болно.

Асуулт 2:

Технологи, апп-даа хөрөнгө оруулж, даатгалыг илүү амар, дижитал болгох тал дээр юу хийж байгаа вэ?

Хариулт Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин:

2026 онд хийж буй төслүүд дунд технологийн шийдлүүдийг шингээж өгсөн. Хиймэл оюун ухаан сүүлийн жилүүдэд маш хурдацтай хөгжиж, хүчин чадал нь сайжирч байна. Хиймэл оюун ухааныг апп-тайгаа хоршуулах шийдлээр явж байна. Жишээлбэл, нөхөн төлбөрийн материалыг хиймэл оюун ухаанаар шийдүүлэх, ажилчдын гар аргаар хийдэг ажлыг автоматжуулах гэх мэт ажлуудыг төлөвлөж, хийж байна.



Асуулт 3:

Ойрын 3-5 жилийн хугацаанд хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг тогтмол өгч чадах баталгаа байна уу?

Хариулт Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин:

Ногдол ашиг олгох эсэх шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл гаргадаг. 2026 ондоо энэхүү 8 төслөө амжилттай хэрэгжүүлж ашиг орлогоо өсгөхийн төлөө ажиллаж, ногдол ашиг олгохын төлөө зорьж ажиллана. Гэхдээ ногдол ашиг олгох эцсийн шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл гаргана.

САНАЛ ХУРААЛТ

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга М.Сэнгэдорж

Танилцуулгын гол агуулга: Санал хураалтын хуудас бөглөх зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХАД АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

"Мандал Даатгал" ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 485,183,633 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ АСУУДЛААР ХУРААСАН ДҮН:

Томас Патрик Холланд-ийг "Мандал Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгох асуудлыг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 484,977,759 буюу 99.96 хувийн саналаар батлав.

Спенс Роберт Хектор Жон-ийг "Мандал Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгох асуудлыг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 485,222,017 буюу 100 хувийн саналаар батлав.

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 485,015,276 ширхэг хувьцааны санал буюу 99.97 хувийн саналаар ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлав.

Тооллогын комиссын дарга М.Сэнгэдорж: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга "Мандал Даатгал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулав.



МАНДАЛ
ДААТГАЛ

“Мандал Даатгал” ХК-ийн 2026 оны 03 сарын 28-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай болж дуусаж байгааг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хэлж, хувьцаа эзэмшигчдийн хуралд идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигч нартаа баяр хүргэн 13 цаг 33 минутад хурал өндөрлөв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Д.Дөлгөөн

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Хурлын-ийн дарга